

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-6

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	3-5
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	5-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны
01 дүгээр сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Т.Энхтүвшин;
Чөлөөтэй: Н.Ганибал, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бейсен.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ц.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Батжаргал хариулж, тайлбар хийв.

Ж.Батжаргал: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Батжаргал хариулж, тайлбар хийв.

Ж.Батжаргал: “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Н.Ганибал, Б.Саранчимэг, Т.Энхтүвшин, Ц.Туваан, Ц.Идэрбат нар ажиллахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 12 цаг 30 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Эрхэм
гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг
айлтгаж, шинэ оны мэнд дэвшүүлье.

Байнгын хорооны өнөөдрийн
хуралдаанд Цогт-Очирын Анандбазар,
Глеуханы Аубакир, Жигжидийн
Батжаргал, Батсүхийн Саранчимэг,
Хаянгаагийн Болорчулуун, Гонгорын
Дамдинням, Цагаанхүүгийн Идэрбат,
Гомпилдоогийн Мөнхцэцэг, Нанзадын
Наранбаатар, Цэдэндамбын
Цэрэнпунцаг нарын гишүүд хүрэлцэн
ирж, ирц 52,6 хувьтай байна. Байнгын
хорооны 6 гишүүн орон нутагт
ажиллаж байгаа. 1 гишүүн эмнэлгийн
чөлөөтэй байна.

Байнгын хорооны хуралдааны ирц
бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө
аж ахуйн байнгын хорооны 2024 оны 01
дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааныг
нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар
хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг та бүгдэд
танилцуулъя.

1. Байнгын хорооны тогтоолын
төсөл. Байнгын хорооны 2024 оны 01
дүгээр сарын хэлэлцэх асуудлын цаглавар
батлах тухай,

2. Байнгын хорооны тогтоолын
төсөл. Ургамлын эрүүл мэнд, ургамал
хамгааллын тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүдийг

хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын
хэсэг байгуулах тухай,

3. Органик бүтээгдэхүүний тухай
хуулийн төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн бусад хуулийн төсөл. Улсын
Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6
гишүүн 2023 оны 03 дугаар сарын 16-ны
өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Ажлын хэсгээс 1 хүсэлт Байнгын
хороонд ирүүлсэн. Органик
бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүдийн анхны хэлэлцүүлгийг ажлын
хэсэг хийж байгаа бөгөөд зарим зүйл,
заалт дээр нь гүйцээн боловсруулах үйл
явц явагдаж байгаа тул энэ удаагийн
хуралдаанаас хойшлуулж өгөөч гэдэг ийм
хүсэлт ирсэн. Тийм учраас энэ 3 дахь
асуудлыг хойшлуулъя.

Хэлэлцэх асуудлын талаар өөр
саналтай гишүүн байна уу? Идэрбат
гишүүн. Үгүй ээ, үгүй тэрийг хэлэлцэх
явцдаа ярья.

Саналтай гишүүн байхгүй тул
хэлэлцэх асуудлын төлөвлөгөөгөө
баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**“Монгол Улсын Их Хурлын 2023
оны намрын ээлжит чуулганы 2024 оны
01 дүгээр сард Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хорооны
хэлэлцэх асуудлын цаглавар батлах
тухай” Байнгын хорооны тогтоолын
төслийг та бүгдэд хүргүүлсэн.**

Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуульд заасны дагуу Монгол Улсын Их
Хурлын дарга 2023 оны 12 дугаар сарын
27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын
2023 оны намрын ээлжит чуулганы 01
дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал
тогтоох тухай 221 дүгээр захирамж
батлагдсан. Энэхүү захирамжийг
үндэслэж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж
ахуйн байнгын хорооны 2024 оны 01
дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар

батлах тухай тогтоолын төсөл цаглаврыг та бүгдэд хүргүүлсэн.

Цаглавар, тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Идэрбат гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүний микрофоныг өгье.

Ц.Идэрбат: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 2023 оны 6 сард Байнгын хорооноос энэ отрын бүс нутагтай холбоотой, тэдний үйл ажиллагаатай, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотойгоор бас ажлын хэсэг гарч, миний бие ахалж, Байнгын хорооноос бас нэр бүхий 5 гишүүн Мөнхцэцэг гишүүн тэргүүтэй гишүүд орж ажилласан. Тэгээд Байнгын хорооноос 10 сард Хөдөө аж ахуйн яам руу бас үүрэг, чиглэл өгсөн тогтоол гаргасан байгаа. Энэ тогтоолын хэрэгжилт ямар шатад яваа вэ гэдгийг бас энэ ирэх 7 хоногт сонсох ийм саналтай байна.

Яагаад гэхээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа энэ отрын бүс нутгуудын захиргаатай, мөн Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Хэрлэнбаян-Улаан, Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Малхын аймаг дундын отрын бүс нутгийн үйл ажиллагаатай бас газар дээр нь очиж танилцсан. Батжаргал гишүүн Төв аймаг, Булган чиглэл рүү бас Бат-Эрдэнэ гишүүд эд нар явж газар дээр нь танилцсан байгаа. Тэгэхээр ер нь Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн асуудлаар ямар шатдаа явав, хэзээ шийдэгдэх вэ гэдэг тал дээр, хэзээ Засгийн газрын хуралдаан руу орох вэ гэдэг дээр бас тодорхой мэдээлэл авъя гэсэн ийм саналтай. Тэгээд үүнийг Байнгын хорооны цаглаварт оруулж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

Ж.Батжаргал: Байнгын хорооноос тогтоол гараад Засгийн газарт чиглэл өгчихсөн. Тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг

авъя гэсэн ийм санал гарч ирж байна. Үүнийг Байнгын хорооны албан тоотгоор ХХААХҮЯ руу явуулаад Засгийн газар луу явуулаад тэгээд хэрэгжилтийг нь аваад Байнгын хорооны гишүүддээ мэдээлчихье. Ийм байдлаар оруулчхаж болж байна уу?

Өөр саналтай гишүүн бий юу? Мөнхцэцэг гишүүн. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Мөнхцэцэг: Энэ манай Байнгын хорооны эрхлэх хүрээний асуудал дотор энэ Байгаль орчны яамнаас би олон жил ярьж байна даа, нөгөө Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, түүний хэрэгжилт хаана явж байгаа вэ. Тэр аль талдаа явж байна. Үүнийгээ хэзээ оруулж ирэх юм бэ. Бид нар бас нэлээн 2 жилийн өмнө нэлээн сайн л ажилласан гэж ингэж бодож байгаа. Юунаас, Байнгын хорооноос бас ажлын хэсэг гараад Батжаргал даргаар ахлуулсан ажлын хэсэг гараад ингээд ажилласан. Тэгээд тогтоол гаргасан. Үүний хэрэгжилт хаана явж байна. Нөгөө Байгаль хамгааллын тухай хууль, нөгөө Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль маань өнөөдөр хаана явж байна. Үүнийг нэг дэх сард нь багтаагаад ингээд явахгүй 1 сар чинь ингээд чуулган завсарлачихна. Тэгээд хавар ингээд худлаа болоод явчихна. Тэгэхээр энэ хууль тогтоомжтой юмнууд дээрээ бас анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тэгэхээр энэ цаглавар дотор тусгаж өгөөч ээ гэдэг ийм саналыг хүргүүлж байна.

Ж.Батжаргал: Энэ талаар ерөнхий мэдээлэл юмнууд авчихсан. Тэгэхээр зэрэг Газрын багц хууль орж ирэх ёстой. Тэр хууль дотор багтаж орж ирэх ёстой. Ирэх 7 хоногт манай Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээний 2 яамтайгаа уулзах гэж байна. ХХААХҮЯ, Байгаль орчны яам. Тэр дотор ерөөсөө энэ байгаль орчныг хамгаалах асуудал энэ тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлаар бас тодорхой

мэдээлэл солилцох, өмнө өгөгдсөн чиглэл, үүргүүдийн талаарх хэрэгжилт, явц, үр дүн ямар байна вэ гэдэг энэ чинь Байнгын хорооноос тогтоол гараад тов тодорхой чиглэл өгөгдчихсөн. Энэ мэдээллүүд бүгд авагдана. Тийм учраас та хэдийг би тэр мэдээллээр хангагдах бололцоо бүрдэнэ гэж ингэж ойлгож байна.

Намрын чуулган үндсэндээ 01 сарын 19 гэхэд завсарлана. Тийм учраас энэ хэлэлцэх асуудлын 01 сарын цаглавар дотор энэ асуудлыг орууламгүй байна. Байнгын хорооноос албан ёсоор бичиг бөгөөд тэр багц хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийнхаа хуулийг яаралтай Улсын Их Хуралд өргөн барих тухай чиглэлийг нь өгчихье гэсэн ийм л бодолтой байна.

Өөр саналтай гишүүн байна уу?
Алга байна.

Ингээд асуулт, саналыг тасаллаа.

Тэгвэл Байнгын хорооны 01 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн саналтай байгаа гишүүд саналаа өгье. Санал хураалт.

81,8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төсөл байна.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг

үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч нь Нанзадын Наранбаатар. Гишүүдэд Гочоогийн Ганболд, Наянтайн Ганибал, Батсүхийн Саранчимэг, Төмөртөгоогийн Энхтүвшин гэсэн ийм бүрэлдэхүүн байна.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр нь татан оролцуулахыг ажлын хэсэг Н.Наранбаатарт зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна Санал байна уу? Туваан гишүүн. Туваан гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Туваан: Юу дарга аа, энэ юу яаж болох юм уу? Нэмэгдэж санал өгч болох юм уу? Тэгвэл нэмж болно гэвэл санал өгчихье. Тэгээд энэ угаасаа энэ Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль дээр одоо хэдүүлээ бас ярихгүй бол болохгүй болчихсон цаг байгаа юм. Юу гэхээр энэ жил манай улсын бараг 80 хувь нь болж байна. Цасан бүрхүүлтэй болоод ер нь зудын эрсдэл нэлээн нүүрлэчихсэн байгаа. Тэгээд энэ зудын хамгийн аюултай нь болохоор зуд ариллаа гээд цас хавар болоод ханзарлаа гээд доороос нь гарч идэх юм байхгүй. Тэгэхээр ер нь энэ ургамал хамгааллын асуудал, энэ ургамлын эрүүл мэнд гэдэг дотор бид нар энэ нөгөө нэг бэлчээрийн асуудал гэж ярьж, улс төрөөсөө айж орхисоор

байгаад ингээд энэ бэлчээр маань ингээд дуусаж байна. Нөгөө хамгийн бэлчээр сайтай гэгддэг зүүн тал Дорнод, Сүхбаатар хүртэл бүр ингээд одоо байгаа бүх мал тийшээ очоод ер нь хүнд болчихлоо.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь бас нэгэнтээ энэ хууль орж ирж байгаа юм чинь энэ хуулийнхаа хүрээнд оруулаад, ярилцаад ингээд явчихвал яасан юм бэ гэсэн бодолтойгоор энэ ажлын хэсэгт орох саналтай байна, санал гаргаж байна.

2 дугаарт нь, энэ бид нар энэ нөгөө ургамал хамгааллын бодистой холбоотой асуудлыг нэлээн ярихгүй бол болохоо больчихож байгаа юм. Бид нар нөгөө нэг хор цацна гэж ярьдаг. Шууд утгаар нь янз бүрийн хортон, мэрэгч тэгээд хог, хог ургамалыг устгах зорилгоор. Тэгээд энэ пестицид, гербицид гээд энэ химийн маш хүчтэй хоруудыг хэрэглэдэг. Тэгээд энэ хэрэглэсэн хор нь хүмүүсийн эрүүл мэндэд маш их сөргөөр нөлөөлдөг. Дэлхий нийтэд үүнийг маш их тийм хатуу хяналт доор, хатуу хуваарь доор ингэж хэрэглээд хоргүйжих хугацааг нь ингээд тооцоод явдаг. Манайд үүнийг ерөөсөө тооцдоггүй. Одоо энэ Монголчууд олон төрлийн хавдраар дэлхийд тэргүүлж байгаагийн нэг үндсэн шалтгаан бол энэ малд хэрэглэж байгаа, дураараа хэрэглэж байгаа тарилга, вакцин, туулга, ургамал хамгааллын бодис нэртэй хэрэглэж байгаа энэ пестицид, гербицит буюу энэ хорууд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар яг энэ хууль орж ирж байгаа дээр нь нэлээн ач холбогдол өгөөд, одоо энэ асуудлыг ярихгүй бол нэг хууль ороод хэлэлцэгдээд, яригдахгүй ингээд явчихаар дахиад нэг хэдэн жил энэ нэлээн анхаарлын гадна үлдчихээд байгаа юм. Жишээлбэл энэ Ургамал хамгааллын хууль чинь бараг 15, 6 жилийн өмнө ингээд батлагдаад дахиж гар хүрээгүй ингээд яваад байгаа. Тэгэхээр ийм саналуудыг бас манай ажлын хэсгийн дарга авч үзэх нь зөв байх.

Тэгээд боломжтой бол ажлын хэсэгт орох санал байна.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийг, бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй санал оруулж ирсэн. Туваан гишүүн энэ ургамал хамгааллын чиглэлээр, ургамал хамгааллын бодисын хэрэглээний чиглэлээр энэ хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх явцад бас тодорхой санал юмнууд байна. Үүнийг шийдвэрлэхэд ажлын хэсэгт орж ажиллая гэдэг санал гаргаж байна. Тэгэхээр аливаа асуудлыг хэлэлцэх явцад санал тэнцээд байхгүй гэдэг үүднээс сондгой бүрэлдэхүүнтэй л ажлын хэсгүүд голдуу л байгуулаад л явдаг л даа бид. Тийм учраас 7 болгоод, ажлын хэсгээ 7 болгоод тэгээд Идэрбат гишүүнийг нэмж оруулаад ингээд Туваан гишүүн, Идэрбат 2 гишүүнийг нэмж оруулаад, ингээд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулах саналыг оруулж байна.

Өөр саналтай гишүүн бий юу? Алга байна.

Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгөөрэй. Санал хураалт.

Тогтоолын төсөл 81,8 хувийн саналаар батлагдлаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөсөн тул Байнгын хорооны хуралдааныг хааж байна.

Гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ